

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	10
3.1. Бараа материалын данстай холбоотой асуудал.....	10
3.2. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал.....	10
3.3. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал .....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан .....	12
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	14
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

### Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭВЛЭХ  
ҮЙЛДВЭР ТӨҮГ-ЫН  
ДАРГА Б.ОТГОНБАЯР ТАНАА

2020.03.13 № 06/803  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус үйлдвэрийн дарга Б.Отгонбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн мөнгөн хөрөнгийн баримтын бүрдлийг хангаж ажиллах, бараа материалыг холбогдох стандартын дагуу бүртгэх, элэгдлийн тооцооллыг үнэн зөв тооцох зэрэг зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 19-өөс 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Мишээл-Од Аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ нь 2019 оны санхүүгийн тайланг Мишээл-Од Аудит ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 17 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь төр, засгийн байгууллагад олон улсын стандартын түвшинд хүрсэн хэвлэлийн бүтэгдэхүүний бүх төрлийн үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хууль тогтоомж, засгийн газрын нийтлэг үйлчилгээний бодлогын хүрээнд үйлүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах, хэвлэлийн бүх төрлийн үйлчилгээг холбогдох шийдвэр, гэрээ, захиалгын дагуу батлагдсан зардал, норм, стандартын дагуу эрхлэн зохион байгуулж, биелэлтийг хангана;
- Өөрийн балансад бүртгэлтэй төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалттай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;
- Хариуцсан ажлын чиглэлээр дотоодын болон гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжтэй холбоо тогтоож, хамтран ажиллах, эрхлэх ажлын хүрээнд хяналт-шинжилгээ судалгаа хийнэ;
- Чиг үүргийн хүрээнд гадаад худалдааны үйл ажиллагаа эрхэлнэ;
- Хэвлэлийн үйлчилгээний мэргэшсэн ажилтан бэлтгэх, давтан сургах ажлыг зохион байгуулна;

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”
- Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”
- Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг 1 дүгээр, “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд”-ийг 2 дугаар, “Автомашин шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г 3 дугаар, “Автомашин эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн норм”-ыг 4 дүгээр, “Автомашин сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаарын норм”-ыг 5 дугаар хавсралтаар баталсан
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд батлагдсан бодлого, журамд нийцүүлэн 2018 онд шинээр боловсруулан мөрдөж байгаа боловч тус үйлдвэрийн үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгаагүй байна.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Даймонд 5.0” программ хангамж ашигладаг байна.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 17 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 550.9 сая төгрөгөөс тооцон 11.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 11.0 сая төгрөгөөр буюу төлөвлөлтийн үе шатанд тооцоолсон түвшнээр тогтоов.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25.8 сая төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, урьдчилж орсон орлого, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, хуримтлагдсан ашиг данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	114.9	143	28.1
Авлага	53.8	64.9	11.1
Бараа материал	62.7	78.5	15.8
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		0.1	0.1
Үндсэн хөрөнгө	447.5	418.2	-29.3
Биет бус хөрөнгө	37.4	37.4	0
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>716.3</b>	<b>742.1</b>	<b>25.8</b>
Өглөг	1.4	6	4.6
Урьдчилж орсон орлого	9.3	24.5	15.2
Өмч: Төрийн	47.9	47.9	0
Хуримтлагдсан ашиг	319.3	333.4	14.1
Эздийн өмчийн бусад хэсэг	319.2	319.2	0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19.2	11.1	-8.1
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>716.3</b>	<b>742.1</b>	<b>25.8</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 28.0 сая төгрөгөөр өссөн нь 2019 оны 12 дугаар сард төрийн байгууллагуудаас хэвлэлийн урьдчилгаа төлбөрүүд хүлээн авсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 11.1 сая төгрөгөөр өссөн нь борлуулалтын авлагын өсөлттэй холбоотой. Тус авлагын үлдэгдэлд Амин инвест ХХК-иас авах 31.3 сая төгрөгийн тооцоо нийлсэн актаар баталгаажсан боловч насжилт өндөртэй авлага бүртгэлтэй бөгөөд барагдуулах арга хэмжээ авч, шүүхэд хандсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 15.8 сая төгрөгөөр өссөн нь Ардчиллын 30 жилийн ойн медалийн үнэмлэх 50000 ширхэг захиалагдаж түүнд шаардлагатай түүхий эд, материалын худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 29.3 сая төгрөгөөр буурсан нь тайланд онд 5.3 сая төгрөгийн компьютер худалдан авч, 34.6 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Өглөг дансны үлдэгдэл 4.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аудитын залруулгаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ногдуулалт нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 15.3 өссөн нь оны эцэст байгууллагуудаас барааны захиалга хийгдэж, урьдчилгаа төлбөрүүд төлөгдсөнөөс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдлийг 8.1 сая төгрөгөөр бууруулж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга дансанд нэмж бүртгэсэн нь өмнөх онуудад данснаас хасагдсан үндсэн хөрөнгөнд хамаарах 8.1 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй байсныг аудитаар залруулсантай холбоотой байна.

## **2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хөрөнгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүргийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд даргын шийдвэрээр Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны зорилтот түвшинг баталсан байна. Зорилтот түвшний орлогын төлөвлөгөөг 453.1 сая төгрөгөөр баталсныг 562.4 сая төгрөгөөр биелүүлж, 109.3 сая төгрөг буюу 24.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ нь тайлант онд 566.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 554.5 сая төгрөгийг зарцуулж, 5.6 сая төгрөгийн орлогын татварын зардал ногдуулж, 5.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Өмнөх оноос орлого 8.4 сая төгрөгөөр, зардал 27.1 сая төгрөгөөр тус тус өсөж ашиг өмнөх оноос 21.2 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний материалын зардлын үнэ өссөн байдал шалтгаалжээ.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 17 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 18 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 20.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 15.8 сая төгрөгийн 3 алдаа, зөрчлийг залруулж, 5.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Дараах 15.8 сая төгрөгийн 3 алдаа, зөрчлийг аудитын явцад залруулсан. Үүнд:



1. Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн акттай тулгахад 2 харилцагчийн 3.3 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад тооцоо нийлсэн акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулсан.

2. Орлогын татварын тооцоог шалгахад ААНОАТ-аас хасагдахгүй зардал 44.5 сая төгрөгийг хасагдах зардлаар тооцож 4.4 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг дутуу ногдуулсан нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 12 дугаар зүйлийн 12.1-т “Дараах зардлыг албан татвар ногдох орлогоос хасаж тооцсоны үндсэн дээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын татварын зардлыг 4.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж залруулсан.

3. Данснаас хасагдсан үндсэн хөрөнгөнд хамаарах 8.1 сая төгрөгийн дахин үнэлгээний хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь НББОУС-16 “Үндсэн хөрөнгө”-ийн 50 дугаар зүйлд “дахин үнэлсэн хөрөнгө нь элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, уг хөрөнгийг худалдсан эсвэл данснаас хассан үед дахин үнэлгээний хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч, уг хөрөнгийн хувьд дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлагдсан дүнг, хуримтлагдсан ашиг дансанд шилжүүлэн бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Данснаас хасагдсан үндсэн хөрөнгөд хамаарах 8.1 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэж залруулсан.

Аудитаар 5.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Тус компанийн үйлдвэрлэлийн өртөг тооцолт нь холбогдох стандарт, хууль, дүрэм журамд нийцсэн эсэх, хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлтэй холбоотой асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 93 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 5.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 11.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Бараа материалын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1. Илрүүлэлт:**

Ашиглалтад тавьж олгон, зарцуулагдсан 1.3 сая төгрөгийн бараа материалыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй бараа материалын дансанд бүртгэлтэй байна. Энэ нь НББОУС 2 Бараа материал стандартын 6-д Бараа материал гэдэг нь дараах хөрөнгүүд юм: (в) “үйлдвэрлэлийн процесст эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа” гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### **3.1.2. Эрсдэл:**

Зардлыг дутуу бүртгэсэн байх

##### **3.1.3. Өгсөн зөвлөмж:**

НББОУС 2 Бараа материал стандартад заасны дагуу бараа материалыг ашиглалтад тавьж олгон, зарцуулсан тухай бүр данснаас хасах

##### **3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Ашиглалтад тавьж олгосон хангамжийн материалыг данснаас хасаж залруулна.

#### **3.2. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### **3.2.1. Илрүүлэлт:**

Мөнгөн хөрөнгийн гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад 2.3 сая төгрөгийн гүйлгээний цахим төлбөрийн баримтыг сугалааны дугаартай, хувь хүнээр гаргуулан авсан байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-т тусгагдсанаар “Төлбөрийн баримт нь бараа, ажил,

үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцэхгүй байна.

### **3.2.2 Эрсдэл:**

Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийх;

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Харилцагч байгууллагаас төлбөрийн баримтыг гаргуулан авахдаа байгууллагын нэр дээр хүлээн авах, хяналт тавьж ажиллах

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийн дагуу баримтыг бүрдүүлж, хяналтыг сайжруулан ажиллана.

## **3.3. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал**

### **3.3.1. Илрүүлэлт:**

Биет бус хөрөнгө дансанд бүртгэлтэй 37.4 сая төгрөгийн цахим программ хангамжид хорогдол тооцоогүйгээс 1.5 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу байгуулсан байна. Энэ нь НББОУС 38(104)-т “Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа ба хорогдол тооцох аргыг санхүүгийн жил бүрийн эцэст дахин шалгана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

### **3.3.2 Эрсдэл:**

Элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан байх;

### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Биет бус хөрөнгийн хорогдлыг ашиглалтын хугацаанд нь системтэйгээр хуваарилж, тайлант үе бүрийн эцэст хорогдуулах хугацаа болон хорогдол тооцох аргыг жил бүрийн эцэст дахин шалгах;

### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	114,960,805.49	143,010,210.87
Дансны авлага	53,771,320.00	64,897,620.00
Татвар, НДШ – ийн авлага		
Бусад авлага		
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	62,746,001.03	78,523,485.44
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		98,000.00
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>231,478,126.52</b>	<b>286,529,316.31</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	447,458,543.13	418,174,403.68
Биет бус хөрөнгө	37,400,000.00	37,400,000.00
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>484,858,543.13</b>	<b>455,574,403.68</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>716,336,669.65</b>	<b>742,103,719.99</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг		
Цалингийн өглөг		
Татварын өр	1,365,331.41	6,008,593.20
НДШ–ийн өглөг		
Богино хугацаат зээл		
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урьдчилж орсон орлого	9,329,029.80	24,545,310.04
Нөөц /өр төлбөр/		
Бусад богино хугацаат өр төлбөр		

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>10,694,361.21</b>	<b>30,553,903.24</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Урт хугацаат зээл		-
Нөөц /өр төлбөр/		-
Хойшлогдсон татварын өр	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>10,694,361.21</b>	<b>30,553,903.24</b>
<b>Эздийн өмч</b>		
Өмч:-төрийн	47,942,966.07	47,942,966.07
- хувийн		
- хувьцаат		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,252,536.77	11,078,269.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эздийн өмчийн бусад хэсэг	319,150,000.00	319,150,000.00
Хуримтлагдсан ашиг	319,296,805.60	333,378,581.68
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>705,642,308.44</b>	<b>711,549,816.75</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>716,336,669.65</b>	<b>742,103,719.99</b>

#### 4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>553,937,691.50</b>	<b>562,404,000.22</b>
Борлуулалтын өртөг	429,565,394.98	454,588,314.12
<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>124,372,296.52</b>	<b>107,815,686.10</b>
Түрээсийн орлого		-
Хүүгийн орлого	3,621,165.25	3,614,817.09
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	53,494,956.99	55,565,822.77
Санхүүгийн зардал		
Бусад зардал	44,354,058.98	44,370,704.08
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг ( алдагдал)		
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>30,144,445.80</b>	<b>11,493,976.34</b>
Орлогын татварын зардал	3,014,445.00	5,586,468.03
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>27,130,000.80</b>	<b>5,907,508.31</b>
<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>27,130,000.80</b>	<b>5,907,508.31</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
<b>Орлогын нийт дүн</b>	<b>27,130,000.80</b>	<b>5,907,508.31</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	47,942,966.07	19,040,957.77	319,150,000.00	292,166,804.80	678,300,728.64
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	47,942,966.07	19,040,957.77	319,150,000.00	292,166,804.80	678,300,728.64
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				27,130,000.80	27,130,000.80
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт	-	211,579.00			211,579.00
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-				-
2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	47,942,966.07	19,252,536.77	319,150,000.00	319,296,805.60	705,642,308.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(8,174,267.77)		8,174,267.77	-
Залруулсан үлдэгдэл	47,942,966.07	11,078,269.00	319,150,000.00	327,471,073.37	705,642,308.44
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-	5,907,508.31	5,907,508.31
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт			-		-
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-			-
2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	47,942,966.07	11,078,269.00	319,150,000.00	333,378,581.68	711,549,816.75



#### 4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>574,074,112.67</b>	<b>633,681,132.50</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	574,074,112.67	633,681,132.50
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого	-	
Бусад мөнгөн орлого		
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>590,385,755.25</b>	<b>603,972,944.21</b>
Ажиллагчдад төлсөн	167,087,153.77	171,305,278.37
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	46,528,502.12	50,552,300.75
Бараа материал худалдан авахад төлсөн	264,538,646.08	284,551,961.42
Ашиглалтын зардалд төлсөн		
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		165,453.64
Хүүгийн төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	66,218,453.30	53,595,397.76
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	46,012,999.98	43,802,552.27
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(16,311,642.58)</b>	<b>29,708,188.29</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>3,621,165.25</b>	<b>3,614,817.09</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	3,621,165.25	3,614,817.09
Хүлээн авсан ногдол ашиг		
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>20,438,000.00</b>	<b>5,273,600.00</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,438,000.00	5,273,600.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(16,816,834.75)</b>	<b>(1,658,782.91)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		

Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг	-	-
		-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
Валютын ханшийн зөрүү		
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(33,128,477.33)</b>	<b>28,049,405.38</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>148,089,282.82</b>	<b>114,960,805.49</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>114,960,805.49</b>	<b>143,010,210.87</b>

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	2020.03.12	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2020/36/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит			Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Мөнгөн хөрөнгийн гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад 2.3 сая төгрөгийн гүйлгээний цахим төлбөрийн баримтыг сугалааны дугаартай, хувь хүнээр гаргуулан авсан байна.	2.3	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Отгонбаяр Д.Нансалгарьд
2	Ашиглалтад тавьж олгон, зарцуулагдсан 1.3 сая төгрөгийн бараа материалыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.	1.3	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Отгонбаяр Д.Нансалгарьд
3	Биет бус хөрөнгө дансанд бүртгэлтэй 37.4 сая төгрөгийн цахим программ хангамжид хорогдол тооцоогүйгээс 1.5 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу байгуулсан байна.	1.5	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Отгонбаяр Д.Нансалгарьд
	<b>Нийт дүн</b>	<b>5.1</b>			

